



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/665

Булган сум

Г Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай" ХХV/05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн орон нутгийн оролцооны хөрөнгөөр (АХБ, орон нутгийн оролцооны хөрөнгө) гадна цэвэр, бохир усны нэмэлт ажлыг 87,994,200 (наян долоон сая есөн зуун ерэн дөрвөн мянга хоёр зуу) төгрөгөөр "Бурхууд" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг "Бурхууд" ХХК-ийн захирал (Т.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

3.Булган аймгийн Дашинчилэн суманд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Эрүүл мэндийн төвийн барилгад орон нутгийн оролцооны хөрөнгө оруулалтаар гадна цэвэр, бохир усны нэмэлт ажилд хяналт тавьж, захиалагчийн хяналтын явцын тайланг өгч ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн орон нутгийн оролцоонд (АХБ, орон нутгийн оролцооны хөрөнгө) гадна цэвэр, бохир усны нэмэлт ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Дос/2024/Засахирамж

6324010944